

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д 2021-2030 онд эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 10 үр дүнг жагсаасны 5 дугаарт “Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна.” гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.29-д “Мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлэн хөгжүүлэх институцийн тогтолцоог бүрдүүлнэ.” гэж, 4.2.31-д “Мэдээллийн технологийн кластерыг хөгжүүлж, гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлнэ.” гэж, 4.2.33-т “Мэдээллийн технологи болон цахим худалдааны салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, хөрөнгө оруулагчдын санаачилгыг дэмжинэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын дор эдийн засгийн тэргүүлэх 16 чиглэлийн хүрээнд “Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.” гэж мөн тодорхойлсон.

Виртуал бүсийг байгуулснаар Монгол улсад эдийн засгийг төрөлжүүлэх, байгалийн баялгаас гадна Монгол хүний оюуны баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах өргөн боломж нээгдэж, мэдээллийн технологийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх онцгой ач холбогдолтой тул тус яамнаас тухай бүр Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд энэхүү цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг тусган ажиллаж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы хуралдаанаар баталсан Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэгт “Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон виртуал бүсийн ажиллах журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу тус Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсрууллаа.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

## **МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.2-т заасан Үндэсний зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх)-ийн үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгоно.

### **Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт**

2.1. Зөвлөл нь Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.4-т заасан байгууллагын төлөөлөл, дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга зэрэг нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улирал тутам хуралдана.

2.3. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар зарлан хуралдуулж болно.

2.4. Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Гишүүн хуралдаанд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд цахимаар оролцож болно.

2.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.6. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, зөвлөмж, мэдэгдэл гаргах бөгөөд хуралдаанаас гарсан шийдвэрт хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.7. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, хуралдаан даргалагч гарын үсэг зурна.

2.8. Зөвлөл хуралдааны дэгийг хэлэлцэн батална.

2.9. Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн холбоо, шинжээч, хувийн хэвшлийн төлөөллийг ажиллуулж болох бөгөөд холбогдох зардлыг зөвлөлийн Ажлын алба хариуцна.

2.10. Гишүүд зөвлөлийн хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дараалан 2 удаа тасалсан тохиолдолд Зөвлөлөөс чөлөөлөгдөнө.

### **Гурав. Зөвлөлийн чиг үүрэг**

3.1.Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батлах талаар тогтоол гаргах;

3.1.2.виртуал бүсийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, зөвлөмж гаргах;

3.1.3.зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, чиглэл өгөх асуудлаар мэдэгдэл гаргах;

3.1.4.Ерөнхий сайдын албан даалгаварын саналыг боловсруулах;

3.1.5.мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг бусад салбарт нэвтрүүлэх зорилгоор холбогдох хууль, тогтоомжийн дагуу зөвлөмж гаргах.

### **Дөрөв. Зөвлөлийн дарга, гишүүний эрх, үүрэг**

4.1.Зөвлөлийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг баталж, хуралдааныг товлох, даргалах;

4.1.2.зөвлөлийг дотоод, гадаадад төлөөлөх;

4.1.3.зөвлөлийн гишүүд, ажлын албанд үүрэг, даалгавар өгөх, биелэлтэд нь хяналт тавих, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд хариуцлага тооцуулах талаар түүнийг томилох эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх;

4.2.Зөвлөлийн гишүүн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар санал оруулах;

4.2.2.зөвлөлийн шийдвэр, үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хариуцсан салбар, чиглэлийн дагуу зохион байгуулах, үр дүнг тайлагнах;

4.2.3.хариуцсан чиглэлийн дагуу Зөвлөл, түүний ажлын албанд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримт гаргаж өгөх;

4.2.4.Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцах, Зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах;

4.2.5.Зөвлөлийн хуралдаанаар өөрийн нэгдмэл сонирхол бүхий этгээдтэй холбоотой асуудлаар хэлэлцэх, танилцуулах бол тухайн гишүүн хуралдаан даргалагчид мэдэгдэж, саналын эрхгүй оролцоно.

4.2.6.хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд Ажлын албанд мэдэгдэж, хуралдаанаар хэлэлцэх асуудалд бичгээр санал өгөх;

4.3.Зөвлөлийн даргын даалгаснаар энэ журмын 4.1-т заасан эрх, үүргийг Зөвлөлийн дэд дарга тухай бүр хэрэгжүүлнэ.

### **Тав.Зөвлөлийн Ажлын алба**

5.1.Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 9.1.8-д заасан Зөвлөлийн Ажлын алба хэрэгжүүлнэ.

5.2. Ажлын алба нь Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1.Зөвлөлийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах;

5.2.2.Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

5.2.3.Зөвлөлийн дарга, гишүүдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

5.2.4.Зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, хэлэлцэх асуудлын жагсаалтыг урьдчилан гаргаж хуралдаан болохоос 2 өдрийн өмнө гишүүдэд хүргүүлэх, зөвлөлийн шийдвэрийг албажуулах, зөвлөлийн гишүүд, холбогдох байгууллагад хүргүүлэх;

5.2.5.Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах, бэлтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх;

5.2.6.Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийн тайланг гаргаж, Зөвлөлд танилцуулах;

5.2.7.Зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;

5.2.8.Зөвлөлийн албан хэрэг хөтлөлтийг зохих журмын дагуу эрхлэх, хадгалах, хамгаалах асуудлыг хариуцах.

5.2.9.Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг гаргах, Зөвлөлийн хуралдаанд танилцуулах

5.2.10.Виртуал бүсийн үйл ажиллагаатай холбогдох иргэд, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг нэгтгэн судалж, холбогдох танилцуулгыг боловсруулж Зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

### **Зургаа. Бусад зүйл**

6.1.Зөвлөлийн дарга, гишүүд нь ашиг сонирхлын зөрчилтэй асуудал, нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар асуудал дэвшүүлэх, санал өгөхийг хориглоно.

6.2.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотой төрийн болон албаны нууцад хамаарах асуудлыг задруулах, хуралдааны шийдвэр баталгаажих хүртэл аливаа мэдээллийг бусдад тараахыг хориглоно.

----o0o----

